

МАНУТХГ-ын Хамгаалалтын 2019 оны 03 дугаар сарын 7-ны
өдрөөс 2019 оны 03 дугаар сарын 15-ны хооронд хийж
хэрэгжүүлсэн ажлын тайлан

2019 оны 03 дугаар
сарын 15-ны өдөр

Өлгий хот

1. Баян-Өлгий аймаг дахь анхан болон давж заалдах шатны шүүхийн Тамгын газар болон Прокурорын газраас "Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт" сэдэвт сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулла. Хэлэлцүүлгийн үеэр аймгийн Прокурорын газрын хяналтын прокурор Б.Ботагэз "Баян-Өлгий аймгийн хэмжээнд 2018 онд гарсан зөрчил, зөрчил гарсан шалтгаан, нөхцөл, түүнээс урьдчилан сэргийлэх арга зам", "Зөрчлийн тухай хууль, Зөрчил хянан шийдвэрлэх тухай хуулийг хэрэгжүүлэхэд анхаарах асуудлууд", Захиргааны хэргийн анхан шатны шүүхийн шүүгч М.Риза "2018 онд Баян-Өлгий аймаг дахь Захиргааны хэргийн анхан шатны шүүхээр шийдвэрлэгдсэн зөрчлийн хэргийн шийдвэрлэлт, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа" сэдвээр тус тус илтгэл тавьж хэлэлцүүлээ. Тус сургалтанд хамгаалалтын захиргааны мэргэжилтэн, байгаль хамгаалагч нар оролцов. Тус арга хэмжээнд 2018 онд гарсан зөрчлийн хэргийн шийдвэрлэлт, зөрчил гарч буй шалтгаан нөхцөл, цаашид авах арга хэмжээг тодорхойлох, зөрчил гаргагчид хүлээлгэж буй хариуцлага, зөрчил шалган шийдвэрлэх эрх бүхий албан тушаалтнаас хууль хэрэглээний явцад гарсан саналыг нэгтгэж хэлэлцэв.
2. Дэлхийн усны өдрийг тохиолдуулан зохион байгуулсан "Усны үнэ цэнэ, хамгаалалт" сэдэвт сургалтанд Дарын, Бугат сумын ЕБС-ийн 9-10 ангийн сурагчид болон "Эко клуб"-ийн гишүүд нийт 82 сурагч хамрагдав. Сургалтанд УТХГ-ын үнэ цэнэ, Монгол Алтайн нурууны УТХГ-ын талаар мэдээлэл өгөв.
3. Хамгаалалтын захиргааны даргын 2019 оны 02 дугаар сарын 26-ны өдрийн "Байгаль хамгаалагч нарт чиглэл өгөх тухай" чиглэлийн дагуу хяналт шалгалтыг эрчимжүүлэх, ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх хяналт шалгалтын ажлыг Даян, Сыргааль, Таванбогд, Хар ямаат, Шар ямаат, Хуурайт, Харагайт чиглэлд тус тус байгаль хамгаалагч нар Хилийн 0165 дугаар анги, 0285 ангиудын заставуудын бие бүрэлдэхүүнтэй хамтарч гүйцэтгэв. Хяналт шалгалтын үеэр ямар нэгэн зөрчил гараагүй болно.
4. Аймгийн ЕБС-ийн сурагчидтай хамтран Ховд голын эргийг цэвэрлэх үйл ажиллагааг амжилттай зохион байгуулав.

МАНУТХГ-ын Хамагаалалтын Захиргаа